



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/1/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Санжаажав**

Утас: 70373089 Цахим хаяг: Sanjaajavs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

᠒᠐25.03.25 № 174  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА Л.БАЯРНЯМ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийгмийн даатгалын сангийн орлогыг 113,592,221.0 мянган төгрөгөөр баталснаас 99.0 хувийн буюу 112,459,276.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бол зардал 97.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд нийгмийн даатгалын байгууллагуудын системийн хэмжээнд программын шинэчлэл хийсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Монгол Улсын Засгийн газраас тэтгэврийн тогтолцооны шинэчлэл хийх, нэмэгдүүлэх бодлого явуулсантай холбоотой тэтгэврийн зардал өмнөх оноос 20,368,296.8 мянган төгрөгөөр өссөн байна.

### **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 93.3 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,031,180,226.91</b>	<b>30,662,014,616.59</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>14,291,323,709.31</b>	<b>18,150,270,174.18</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>14,291,323,709.31</b>	<b>18,150,270,174.18</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>14,291,323,709.31</b>	<b>18,150,270,174.18</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	14,291,323,709.31	18,150,270,174.18
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>13,739,856,517.60</b>	<b>12,511,744,442.41</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	8,488,810,974.62	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,853,704,019.54	4,854,170,590.54
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	7,093,794,603.36
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>397,341,523.44</b>	<b>563,779,248.51</b>
33510	Байгууллагаас авах авлага	397,341,523.44	245,302,132.06
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	318,477,116.45
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>28,031,180,226.91</b>	<b>30,662,014,616.59</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,506,854,981.37</b>	<b>1,701,714,442.99</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,506,854,981.37</b>	<b>1,701,714,442.99</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>543,944,920.47</b>	<b>729,346,958.33</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	543,944,920.47	-
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>-</b>	<b>729,346,958.33</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	57,596,655.71
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	657,518,970.81
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	-	14,231,331.81
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>962,910,060.90</b>	<b>972,367,484.66</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	962,910,060.90	972,367,484.66
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>26,524,325,245.54</b>	<b>28,960,300,173.60</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>26,524,325,245.54</b>	<b>28,960,300,173.60</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>26,524,325,245.54</b>	<b>28,960,300,173.60</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	33,284,641,103.26	25,401,386,692.62
51220	Тайлант үеийн үр дүн	(6,760,315,857.72)	3,558,913,480.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>28,031,180,226.91</b>	<b>30,662,014,616.59</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>164,117,081,550.89</b>	<b>297,099,327,752.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>104,401,848,214.67</b>	<b>110,591,189,921.19</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>104,401,848,214.67</b>	<b>110,591,189,921.19</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	71,250,368,197.14	90,780,575,099.31
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,467,344,713.06	9,531,306,824.89
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	7,603,428,579.07	6,935,351,938.16
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,485,977,751.72	3,343,956,058.83
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	16,594,728,973.68	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>262,479,500.99</b>	<b>260,097,290.19</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>262,479,500.99</b>	<b>260,097,290.19</b>
120002	Хүүгийн орлого	102,047,740.69	103,422,714.17
120003	Торгуулийн орлого	-	1,459,500.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>45,609,371.30</b>	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,609,371.30	-
120009	Бусад орлого	114,822,389.00	155,215,076.02
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>59,452,753,835.23</b>	<b>186,248,040,540.62</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>16,791,394,681.00</b>	<b>34,660,385,740.62</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,791,394,681.00	34,660,385,740.62
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>42,661,359,154.23</b>	<b>151,587,654,800.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,661,359,154.23	151,587,654,800.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>170,877,397,408.61</b>	<b>293,540,414,271.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>170,877,397,408.61</b>	<b>293,540,414,271.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,481,980.00</b>	<b>17,949,274.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,481,980.00</b>	<b>17,949,274.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	8,846,854.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,481,980.00	9,102,420.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>170,870,915,428.61</b>	<b>293,522,464,997.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>142,332,997,728.00</b>	<b>184,494,530,097.81</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	142,332,997,728.00	184,494,530,097.81
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,537,917,700.61</b>	<b>109,027,934,899.21</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,537,917,700.61	109,027,934,899.21
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(6,760,315,857.72)</b>	<b>3,558,913,480.98</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(6,760,315,857.72)</b>	<b>3,558,913,480.98</b>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны НИМТ ДҮН 1,324,13,000 9055438
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	33,329,028,586.27	33,329,028,586.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(44,387,483.01)	(44,387,483.01)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	33,284,641,103.26	33,284,641,103.26
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,760,315,857.72)	(6,760,315,857.72)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	26,524,325,245.54	26,524,325,245.54
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	26,524,325,245.54	26,524,325,245.54
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,122,938,552.92)	(1,122,938,552.92)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	25,401,386,692.62	25,401,386,692.62
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	3,558,913,480.98	3,558,913,480.98
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	28,960,300,173.60	28,960,300,173.60

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>172,508,080,141.88</b>	<b>317,704,969,642.46</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>104,126,410,869.43</b>	<b>131,601,507,578.16</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>104,126,410,869.43</b>	<b>131,601,507,578.16</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	71,089,350,230.95	89,290,045,072.34
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,449,460,212.32	9,295,748,472.85
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	7,573,118,356.51	10,358,115,724.17
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,479,072,300.16	3,351,035,560.50
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	16,535,409,769.49	19,306,562,748.30
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>274,932,818.22</b>	<b>291,903,864.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>274,932,818.22</b>	<b>291,903,864.30</b>
120002	Хүүгийн орлого	87,907,189.86	104,441,144.82
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>187,025,628.36</b>	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	187,025,628.36	-
120009	Бусад орлого	-	187,462,719.48
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>68,106,736,454.23</b>	<b>185,811,558,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>25,445,377,300.00</b>	<b>34,223,903,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,445,377,300.00	34,223,903,400.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>42,661,359,154.23</b>	<b>151,587,654,800.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,661,359,154.23	151,587,654,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>170,534,772,300.02</b>	<b>313,846,023,177.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>170,534,772,300.02</b>	<b>313,846,023,177.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,481,980.00</b>	<b>230,789,626.60</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,481,980.00</b>	<b>17,949,274.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	8,846,854.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,481,980.00	9,102,420.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>212,840,352.60</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	212,840,352.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>170,528,290,320.02</b>	<b>313,615,233,550.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>141,990,372,619.41</b>	<b>184,302,699,420.64</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	141,849,449,946.94	184,302,699,420.64
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	140,922,672.47	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>28,537,917,700.61</b>	<b>129,312,534,130.35</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,537,917,700.61	129,312,534,130.35
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,973,307,841.86</b>	<b>3,858,946,464.87</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>1,973,307,841.86</b>	<b>3,858,946,464.87</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,318,015,867.45	14,291,323,709.31
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,291,323,709.31	18,150,270,174.18


## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>188,466,468,800.00</b>	<b>184,320,648,694.64</b>	<b>(4,145,820,105.36)</b>	<b>97.80</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>188,466,468,800.00</b>	<b>184,320,648,694.64</b>	<b>(4,145,820,105.36)</b>	<b>97.80</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>19,409,200.00</b>	<b>17,949,274.00</b>	<b>(1,459,926.00)</b>	<b>92.48</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>19,409,200.00</b>	<b>17,949,274.00</b>	<b>(1,459,926.00)</b>	<b>92.48</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,903,300.00	8,846,854.00	(1,056,446.00)	89.33
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,505,900.00	9,102,420.00	(403,480.00)	95.76
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>188,447,059,600.00</b>	<b>184,302,699,420.64</b>	<b>(4,144,360,179.36)</b>	<b>97.80</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>188,447,059,600.00</b>	<b>184,302,699,420.64</b>	<b>(4,144,360,179.36)</b>	<b>97.80</b>
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	188,447,059,600.00	184,302,699,420.64	(4,144,360,179.36)	97.80
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>188,466,468,800.00</b>	<b>146,683,180,290.94</b>	<b>(41,783,288,509.06)</b>	<b>77.83</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>34,223,903,400.00</b>	<b>34,223,903,400.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
Улсын төсвөөс санхүүжих	34,223,903,400.00	34,223,903,400.00	-	100.00
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>154,242,565,400.00</b>	<b>112,459,276,890.94</b>	<b>(41,783,288,509.06)</b>	<b>72.91</b>
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	154,242,565,400.00	112,459,276,890.94	(41,783,288,509.06)	72.91
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,291,323,709.31	<b>14,291,323,709.31</b>	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,150,270,174.18	<b>18,150,270,174.18</b>	-

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын багц хуулиудыг хэрэгжүүлэх, сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуульд заасан хугацаанд тогтоон олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа байгууллага юм.



### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчлэн найруулсан хууль мөрдөгдөж, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд УСНББОУС-д заасан үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын тайлангийн зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,630,834.4 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.



**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,291,323.70	18,150,270.20	3,858,946.50
Авлага	13,739,856.50	12,511,744.40	(1,228,112.10)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>28,031,180.20</b>	<b>30,662,014.60</b>	<b>2,630,834.40</b>
Өр төлбөр	1,506,854.90	1,701,714.40	194,859.50
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	26,524,325.30	28,960,300.20	2,435,974.90
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>28,031,180.20</b>	<b>30,662,014.60</b>	<b>2,630,834.40</b>

Тайлант онд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 3,858,946.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоол, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоол, 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор тус тус тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүр шинэчилсэн, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой харилцах дансны үлдэгдэл өсөхөд голлон нөлөөлжээ.

Авлага данс 1,228,112.1 мянган төгрөгөөр буурсан нь 2024 оныг тус байгууллагаас “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил” болгон зарлаж өр, авлагыг бууруулах, хамрагдалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласантай холбоотой байна. Авлага нийт дүнгээр буурсан боловч тайлант онд хувь хүнээс авах авлага өссөнийг дотоод хяналт шалгалтаар илрүүлж, нийт 121,358.4 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тавигдаж, хуваарийн дагуу барагдуулж байна.

Тайлант онд өр төлбөр 194,859.5 мянган төгрөгөөр өссөн нь даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсэн амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 28,960,300.2 мянган төгрөг болж 2,435,974.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт орлогыг 105,213,997.5 мянга төгрөгөөр, зарлагыг 187,685,978.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид

хүргүүлснийг төсвийн төслийн саналаас зардлыг 58,239.3 мянган төгрөгөөр бууруулж 187,627,739.1 мянган төгрөгөөр, орлогыг 105,213,997.5 мянган төгрөгөөр буюу хэвээр баталсан байна.



### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тодотголоор нийт орлогыг 8,378,223.5 мянган<sup>24</sup> төгрөгөөр, зарлагыг 838,729.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 154,242,565.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 34,223,903.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 112,459,276.9 мянган төгрөг, улсын төсвөөс 34,223,903.4 мянган төгрөг, нийт 146,683,180.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 129,312,534.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 184,320,648.7 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь сангаас олгосон тэтгэвэр тэтгэмжийн гүйцэтгэлтэй холбоотой байна.

*Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71900-Нийгмийн даатгалын сан	188,466,468.80	184,320,648.69	4,145,820.10	97.80
	<b>Нийт</b>	<b>188,466,468.80</b>	<b>184,320,648.69</b>	<b>4,145,820.10</b>	<b>97.80</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Санжаажав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дүгээр сарын 21-ний өдрийн 119 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 188,457,468.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,884,574.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг бүрэн байршуулсан байв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2,139.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, төлбөрийн акт тогтоосныг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4: Төлбөрийн актын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,139.6	1	2,139.6	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>2,139.6</b>	<b>1</b>	<b>2,139.6</b>	<b>100</b>

##### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 728.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд ажилгүйдлийн даатгалын сангаас 1 иргэнд нийт 728.5 мянган төгрөгийн тэтгэмж илүү тооцож, олгосон байна. Энэ нь Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3-д *“Даатгуулагч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар болон бусад хэлбэрээр түр ажил, хөдөлмөр эрхэлсэн бол түүний тэтгэмжийг түдгэлзүүлэн зогсоож тэтгэмж олгох хугацааг уг ажил, хөдөлмөр гүйцэтгэсэн хоногоор сунгана”* гэж заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

Дээрх актын биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Тоо		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 1 иргэнд ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж илүү олгосон байна	1	728.5	1	728.5								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>728.5</b>	<b>1</b>	<b>728.5</b>								

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Улаанбаатар  
Булган  
Ховд